



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 25 дугаар тойргийн 34 дүгээр хэсэгт хамаарах хэсгийн төвийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар тогтоолын 16 дугаар хавсралтын 34 дүгээр хэсэгт хамаарах хэсгийн төвийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Өөрчлөлт орсон хэсгийн нутаг дэвсгэр, төвийг нийтэд мэдээлэхийг Хурлын Ажлын алба /даргын үүрэг гүйцэтгэгч О.Батмөнх/, дүүргийн Засаг даргын Тамгын газар /Б.Цэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА




ЛАРИУНТУЯА

1150100103

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын
14-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ХЭСЭГ,
ТҮҮНИЙ НУТАГ ДЭВСГЭР, ТӨВ



Хэсгийн дугаар	Харьяалах нутаг дэвсгэр	Хэсгийн төв
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 16 ДУГААР ХОРОО		
34 дүгээр хэсэг	Согоот 73, 74, 75, 76, 77, 77а, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91 дүгээр гудамж	139 дүгээр бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор байрны цэцэрлэгийн байр